

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ДОТООД АУДИТЫН МЭДЭЭЛЭЛ

2024.07.22

д/д	Дотоод аудитын нэр	Үр дүнгээр өгсөн дүгнэлт	Зөвлөмж	Биелэлтийн хувь	Дахин өгсөн зөвлөмжийн тоо
1	Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит	Сайжруулах шаардлагатай	Зөвлөмж: 16	70.75 хувь	5
2	Гаалийн ерөнхий газрын Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын 2022, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит	Сайжруулах шаардлагатай	Зөвлөмж: 23	2024.09.30-ны өдрөөр дүгнэнэ.	-
3	Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын 2022 он, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын үр дүнгээр хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийн дүгнэлт	Сайжруулалт шаардлагатай	Зөвлөмж-28	90 хувь	байхгүй
4	Ховд аймгийн Булган дахь гаалийн газрын 2022 он, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын үр дүнгээр хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийн дүгнэлт	Хангалттай	Зөвлөмж-10	95 хувь	байхгүй

1. 2024 оны эхний хагас жилд 2 дотоод аудитын үр дүнгээр нийтлэг болон тусгайлсан 39 зөвлөмжийг улирал, хагас жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр хүргүүлж, ирүүлсэн биелэлтийг эргэн хянаж, Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг 70.75 хувиар дүгнэв. Эдгээрээс гүйцэтгэл дутуу 5 зөвлөмжийг 2024 оны 3 дугаар улиралд үргэлжлүүлэн хүргүүлэхээр шийдвэрлэв. Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын зөвлөмжийг дүгнэх хугацаа болоогүй байна. Мөн 2023 оны сүүлийн хагас жилд хийгдсэн 2 дотоод аудитын зөвлөмжийг 2024 оны 1 дүгээр улиралд дүгнэж, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газраас ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг 90 хувь, Ховд аймгийн Булган дахь гаалийн газрын ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг 95 хувиар үнэлж, удирдлагад танилцуулав.

2. Үндэсний аудитын газраас гаалийн байгууллагын 2023 оны санхүү, төсвийн гүйцэтгэлд хийсэн шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан ба ирүүлсэн зөвлөмж, албан шаардлага, актын хэрэгжилтийг хангахаар 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг ГЕГ-ын даргаар батлуулан гүйцэтгэлийг хангуулж, харьяа 19 гаалийн газар, хороодын үйл ажиллагаанд заавар, чиглэл өгч, сургалт явуулж, үр дүнг тооцов.

3. Сангийн яамнаас гаалийн байгууллагын 2022, 2023 оны санхүүгийн шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан ба ирүүлсэн зөвлөмж, албан шаардлага, актын хэрэгжилтийг хангахаар төлөвлөгөө боловсруулан, сүүлийн хагас жилд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР